



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023. 04. 28.

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны  
тайлан, санхүүгийн тайлангийн талаар  
ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт,  
Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа  
эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан,  
санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ын дүгнэлтийг хангалттай гэж  
үзсүгэй.
2. Стратеги төлөвлөгөө, гаргасан зөвлөмжийн гүйцэтгэлд анхаарч ажиллахыг  
Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



/ Э.БАТБОЛД /



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023. 04. 28.

№ 02

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны  
тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн "Э-Транс ложистикс" Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. "Э-Транс Ложистикс" Хувьцаат Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагааны талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: .....



Э.БАТБОЛД /



## Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023.04.28.

№ 03

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны  
тайлан, санхүүгийн тайлангийн талаар  
ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт,  
Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа  
эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

3. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан,  
санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ын дүгнэлтийг хангалттай гэж  
үзсүгэй.
4. Үйл ажиллагааны төлөвлөгөө, гаргасан зөвлөмжийн гүйцэтгэлд анхаарч  
ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: .....



Э.БАТБОЛД /



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023.04.28

№ 04

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны стратеги  
төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн 2023 оны стратеги төлөвлөгөөг баталсугай.
2. Төлөвлөгөөнд дурьдагдсан ажлуудыг чанартай хийж гүйцэтгэх, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал / Ч.Амарсанаа/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: ..... / Э.БАТБОЛД /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023. 04. 28.

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр
  - 1) Данзан ДАЯНБИЛГҮҮН
  - 2) Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ
  - 3) Шараа ШИНЭБАЯР
  - 4) Чулуун АМАРСАНАА
  - 5) Чулуун ЭНХБОЛД
  - 6) Энхболд БАТБОЛД
2. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
  - 1) Халтар БАТХИШИГ
  - 2) Чулуунбаатар ОРГИЛ
  - 3) Жаргалсайхан ЭНХТУЛГА нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



Э.БАТБОЛД /



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023. 04. 28.

№ 06

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг 5,300,000 төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА ..... / Э.БАТБОЛД /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023. 04. 28.

№ 07

Улаанбаатар хот

Шийдвэрийг зөвшөөрөх тухай

“Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас  
**ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс танилцуулсан Ногдол ашиг хувиарлах шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА ..... / Э.БАТБОЛД /



# “Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023.04.28

Улаанбаатар хот

“Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 сарын 28-ны өдөр “ БиДиСек ҮЦК “ ХК-ны хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах программаар 10 цагаас эхлэв.

Хурлын дэгийг Хурлын дарга Э.Батболд уншиж танилцуулсны дараа дэгийн дагуу тооллогын комиссын ирцийн тогтоолыг хурал зохион байгуулах хорооны гишүүн Б.Онон танилцуулснаар хурлыг эхэллээ.

“Э-Транс ложистикс” ХК нь нийт саналын эрх бүхий 46,200,000 ширхэг хувьцаатай бөгөөд нийт саналын эрх бүхий хувьцааны 90,76% хувь буюу 41,929,780 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан.

## **Хурлаар хэлэлцэх асуудлууд:**

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
4. Компанийн 2023 оны стратеги төлөвлөгөөг батлах
5. ТУЗ-ийн 2023 оны цалин урамшууллын төсөв батлах
6. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
7. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

## **Компанийн ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа:**

Компанийн 2022 оны санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг танилцуулав. Компани нь 2022 санхүүгийн тайландаа Их Монгол хөлөг ХХК-ны аудитын компаниар аудит хийлгэсэн. Тэгээд хараат бус аудитын дүгнэлтээс танилцуулая. Хараат бус аудит нь компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын Олон улсын Стандартын дагуу үнэн, шударгаар толилуулсан байна гэж дүгнэж байна гэсэн зөрчилгүй дүгнэлт гарсан байна. Манай компанийн тархалтын мэдээнээс авсан хувьцаа эзэмшигчдийн судалгааг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөр гаргаж ирүүлснийг оруулсан байна. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 301,833,0 байгаа дансны авлагын хувьд 16,241,0 урьд оныхоос өссөн энэ нь урьдчилж төлсөн үйлчилгээний төлбөрүүдэй холбоотой авлагууд үүссэн. Үндсэн хөрөнгийн хувьд 4,355,301,348 төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байгаа. Дансны өглөгийн хувьд өглөгө байхгүй, татварын өглөгийн хувьд энд үзүүлсэн ААНОАТ, НӨАТ, ХХОАТ зэрэгт өглөгтэй харагдаж байгаа ч 2022 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон тайлан болохоор ингэж харагдаж байгаа ба энэ жилд төлөөд одоо өглөггүй болсон байгаа. Татвараа төлөөд нийт ашиг нь 25 сая төгрөг байгаа хуримтлагдсан ашиг 443,864,647 төгрөгийн алдагдалтай байгаа. Борлуулалтын орлого өмнөх оныхоос буурсан үйл ажиллагааны тайлан дээр танилцуулагдах байх ачилтын орлого буурсан төмөр замаар тээвэрлэгдэж байгаа ачилтын орлого буурсан баталгаат



агуулахад хадгалагдаж байгаа ачааны орлого буурсан. Энэ нь удаан хугацаагаар түрээслэгдэж байгаа ачаа бараа буурсантай холбоотой байгаа. Мөн манай хяналтын бүсээр 2 ачааны терминал орж ирдэг байсан бол одоо зөвхөн 1 төрлийн ачаа хяналтын бүсээр орж ирж байгаа өрсөлдөгч Дардан ложистикс ХХК-тай ачаа бараагаа хуваалцаж байгаагаас мөн шалтгаалж байгаа. Үйл ажиллагааны зардал 1,205,929,825 төгрөг энд элэгдэлийн зардал, үйл ажиллагаатай холбоотой бүх зардал орсон байгаа. Ер нь зардал өссөн гол шалтгаан нь ковидын үеийн хөнгөлөлт чөлөөлөлтүүд байхгүй болсонтой холбоотой цахилгааны зардал, нийгмийн даатгалын зардал, төмөр замтай холбоотой зардалууд 30-45% болж өссөнтэй холбоотой. Санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт асуултанд хариулая.

### **Компанийн Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:**

2022 оны үйл ажиллагааны тайланг тавьж байна. Гүйцэтгэх удирдлагын зүгээс үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээгээ Санхүүгийн зохицуулах хороо бусад байгууллагад хүргүүлж байсан. Тайлантай холбоотой бүх зүйлүүд та бүхэнд хүргэгдсэн байгаа тул нуршуу яриад яахав. Хятадын хил хаалттай байсан болохоор манай ачааны терминал шилжүүлэн ачилт 50 вагон ачааг шилжүүлэн ачсан нь өмнөх оны мөн үеэс даруй 294 вагоноор буурсан мөн гаалийн хяналтын бүсэд орж ирсэн тээврийн хэрэгсэл, ачаа бараа 2021 онд 14677 орж ирж байсан бол 2022 онд 6489 болж 8188-ээр буурсан зэрэг сөрөг үзүүлэлттэй жил болсон байна. Салбар зам дахь шилжүүлэн ачилт ерөнхийдөө бүрэн зогссон байдалтай байсан тул УБТЗ-аас салбар зам ашиглан Хятад улсаар орж ирж байгаа задгай ачааг мөн өөрийн техник тоног төхөөрөмж, хүн хүчийг ашиглан засаж янзлах, жин тонныг тэнцүүлэх хүсэлт ирүүлснийг ажил хэрэг болгосны дүнд вагоны даац хэтрэлт, ачааг засаж янзлах ажлаас 112,6 сая төгрөгийн ашигтай ажил гүйцэтгэсэн. Жилийн стратеги төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг дүгнэж үзэхэд өөрсдийн нөхцөл бололцоонд түшиглэн гаалийн хяналтын бүсээ MNS 5832:2007 стандартад нийцүүлж зам талбайг засах ажлыг хийж гүйцэтгэн өнөөдрийн байдлаар нийт 231,583,000 төгрөгийн хавтангаар 3552м<sup>2</sup> талбайг хучиж янзалсан, гаалийн байгууллагаас шаардсаны дагуу гаалийн хяналтын бүс дэх гаалийн камерын хяналтыг 12 камерыг шинэчилж ажилласан. 2022 оны хувьд БНХАУ-аас хилийн хорио цээрийн дэглэм хэрэгжиж хилээр орох импортын ачаа бараа хязгаарлагдмал зөвхөн чингэлэг тээврийн үйл ажиллагаа, шинэ тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж л тодорхой тоо хязгаартай тээвэрлэгдэж байсан. Чингэлэг тээврийн зарим хэсгийг өөрийн гаалийн хяналтын бүсээрээ дамжууланг авах талаар гаалийн байгууллагатай тохиролцоонд хүрсэн боловч техник хэрэгслийн байдлаас шалтгаалан энэхүү ажил зогссон. Харин шинээр орж ирж байгаа тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг өөрийн гаалийн хяналтын бүсээр дамжуулах, жин тонныг нь баталгаажуулах зэрэг ажлыг тодорхой хэмжээнд хийж гүйцэтгэж ажилласан гэсэн тайлагналуудаас дурьдаж байна.

### **Компанийн ТУЗ-ийн дарга Э.Батболд:**

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг уншиж танилцуулав. Э-Транс ложистикс хувьцаат компани нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээгээр 25,442,661.21 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байх ба өнөөгийн нөхцөл байдалд ямар ч байсан тодорхой хэмжээгээр алдагдалгүй ажиллаж компанийн үйл ажиллагааг эрсдэлд оруулалгүй авч явсан нь сайшаалтай гэж

дүгнэж байна. Компанийн тайлан мэдээгээр хагас жилийн байдлаар 168,363,503.33 төгрөгийн алдагдалтай ажиллаж цаашдын үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд хэцүү байсан боловч энэхүү алдагдалаа нөхөж бага ч гэсэн ашигтай гаргаж чадсан нь үйл ажиллагаагаа зөв удирдан чиглүүлж ажиллажээ гэж үзэж болохоор байна. 2022 оны хувьд хил гаалийн асуудал ихтэй өөрөөр хэлбэл БНХАУ-ын хил 2021 оны 10 сарын 14-нөөс бүрэн хаалттай 2 сар болсны дараа зөвхөн шинэ тээврийн хэрэгсэлийг 12 сарын 11-нээс хилийн 0 цэгээс зөөвөрлөж эхэлсэн. Эдгээр нь өдөрт хилээр нэвтрэх тээврийн хэрэгсэлийн тоо хэмжээнд хязгаарлалт тогтоож 40-50 машин орж ирж байсан. Үүний дараагаар шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн 12 сарын 29-нөөс Хятадын гаалийн хашаанд байсан ачаатай машинуудыг оруулж ирсэн, 2022 оны 10 сарын 06-наас чингэлэг тээвэр орж ирсэн, 2022 оны 09 сарын 12-ноос дугаартай тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрч эхэлсэн зэрэг нөхцөл байдал тогтмол өөрчлөгдсөн, үйл ажиллагаагаа удирдан чиглүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдалд амжилттай ажиллажээ. Хил гаалийн үйл ажиллагаагаа дагаад үндсэн үйл ажиллагааны хувьд ихээхэн доголдолтой байсан нь харагдаж байна. 2021 онд төмөр замаар 344 вагон импортын ачаа, 548 экспортын ачаа шилжүүлэн ачиж 128 сая төгрөгийн орлого олж байсан бол 2022 онд зөвхөн 50 вагон шилжүүлэн ачиж 27 сая орчим төгрөгийн орлого олжээ. Гаалийн хяналтын бүсээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн хувьд ч мөн 2 дахин буурсан үзүүлэлттэй байна. 2021 оны хувьд 14,677 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан бол 2022 онд 6,489 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн, гаалийн баталгаат агуулахад хадгалуулсан ачаа барааны хадгалалт мөн буурсан зэрэг бүхий л мөнгө санхүүгийн гол гол эх сурвалжууд нь буурсан үзүүлэлттэй байгааг гаргасан тайлан мэдээнээс дүгнэж үзэв. Гүйцэтгэх удирдлагаас үйл ажиллагаагаа доголдуулахгүйн тулд бүхий л арга хэмжээнүүдийг авч ажилласан нь тайлангаас харагдаж байгаа ба тухайлбал гаалийн хяналтын бүсийн талбайгаа ашиглан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах замаар уул уурхайн бүтээгдэхүүнийг буулгаж ачих, хадгалах, салбар төмөр замаараа даац хэтэрсэн, буруу ачсан ачаатай вагонуудыг хүлээн авч шилжүүлэн ачих, засварлах, өөрийн эзэмшлийн пүүг гаалийн байгууллагад ашиглуулан пүүлсний хураамж авах, зарим агуулах өрөө тасалгаагаа түрээслэх, цайны газраас хоол захиалгаар хүргэлтээр хүргэх зэрэг арга хэрэгсэлүүдийг авч хэрэгжүүлсэн нь хагас жилийн алдагдалыг арилгахад чухал нөлөө үзүүлсэн байна. Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдлыг судлаж үзээд санхүүгийн цэвэр ашиг ногдол ашиг тараах хэмжээнд байхгүй байгаа ч компанийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлээс ногдол ашиг тарааж болох юм гэж үзэн төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ хурлаар энэ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж мөнгөн хөрөнгийн үлдэгдэлээс нэгж хувьцаанд 3 төгрөг байхаар 46,200,000 хувьцаанд нийт 138,600,000 төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн.

#### **Компанийн гүйцэтгэх захирл Ч.Амарсанаа:**

Компанийн 2023 оны стратеги төлөвлөгөөг танилцуулав. Өмнөх жилийнхтэй адилаар бид төлөвлөгөөгөө орлого бүтээгдэхүүн сайжирч эерэгээр харсан зорилтоо тавьж ажиллана гэж төсөөлсөн төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа. Гэхдээ хувьцаа эзэмшигч та бүхэн энэ байдлыг бас сайтар бодож танилцаарай гэж хүсэж байна.

#### **БидиСек ҮЦК ХК: Б.Онон:**

2023 оны стратеги төлөвлөгөөн дээр манай компанийн зүгээс уулзаж сайтар ярилцая гэсэн санал ирүүлсэн байна.

**Компанийн ТУЗ-ын дарга Э.Батболд:**

За ойлголоо уулзаж ярилцая

Дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ийн 2023 оны цалин урамшууллын төсөв батлах асуудлыг хүрээнд зардлын задаргааг уншиж танилцуулав.

Хэлэлцэх асуудлын дагуу ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлын дагуу ТУЗ-д нэр дэвшигч нарыг танилцуулав.

Ердийн гишүүнд нэр дэвшигч нар:

1. Ч.Амарсанаа
2. Ч.Энхболд
3. Э.Батболд
4. Д.Даянбилгүүн
5. Б.Лхагвадорж
6. Ш.Шинэбаяр

Хараат бус гишүүнд нэр дэвшигч нар:

7. Х.Батхишиг
8. Ч.Оргил
9. Ж.Энхтулга

Ногдол ашиг тараах талаар гаргасан шийдвэр:

1. “Э-Транс Ложистикс” ХК-ны 2022 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийн 46 хувь буюу нэгж хувьцаанд 3 төгрөгөөр тооцон 46,200,000 хувьцаанд нийт 138,600,000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэх өдрөөр тасалбар болгосугай.

3. Ногдол ашиг хуваарилах ажлыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан зохион байгуулж 2023 оны 12 сарын 31-ний дотор тухайн компанийн дансанд шилжүүлж дуусгах ба ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаад даалгасугай гэсэн тогтоол гаргасан байна.

Хэлэлцсэн асуудалуудтай холбогдуулж асуулт асуух хувьцаа эзэмшигч байхгүй байсан тул асуулт хариулт, санал хэлэх үйл ажиллагаа дуусч санал хураах үйл ажиллагаа эхлэв.

Тооллогын комисс санал хураалтын дүн болон тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

“Э-Транс ложистикс” ХК-ийн саналын эрхтэй нийт 46,200,000 ширхэг хувьцаанаас 90.76% буюу 41,929,780 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,929,780 ширхэг хувьцаатай 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,929,780	100%	0	0%	0	0%

2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангын дүгнэлт батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,929,780 ширхэг хувьцаатай 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,929,780	100%	0	0%	0	0%

3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,929,780 ширхэг хувьцаатай 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,929,780	100%	0	0%	0	0%

4. Компанийн 2023 оны стратеги төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,929,780 ширхэг хувьцаатай 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 55.09% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 44.91% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
23,100,000.00	55.09%	0	0%	18,829,780.00	44.91%

5. ТУЗ-ийн 2023 оны цалин урамшууллын төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,929,780 ширхэг хувьцаатай 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
------------	--	------------	--	------------	--

Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,929,780	100%	0	0%	0	0%

6. Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,929,780 ширхэг хувьцаатай 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,929,780	100%	0	0%	0	0%

**Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.**

7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд 41,929,780 ширхэг хувьцаатай 4 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ч.Энхболд	16.51%	41,580,000
2	Ч.Амарсанаа	16.51%	41,580,000
3	Э.Батболд	16.51%	41,580,000
4	Д.Даянбилгүүн	16.82%	42,367,005
5	Б.Лхагвадорж	16.82%	42,367,005
6	Ш.Шинэбаяр	16.82%	42,367,005

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ж.Энхтулга	33.12%	41,580,000
2	Х.Батхишиг	33.75%	42,367,005
3	Ч.Оргил	33.12%	41,580,000

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

**Хурлаас гарах тогтоолын төслийг Хурал даргалагч Э.Батболд танилцууллаа.**

Хэлэлцэх асуудал болон санал хураалттай холбоотой ямар нэгэн санал гомдол гараагүй тул 11:20 цагт Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулан хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга:



/

Э.Батболд /

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



/

С.Ганбат /

# Хурлаар хэлэлцэх асуудал

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт;

2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан;

3. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн МҮЗ-ийн дүгнэлт;

4. Компанийн 2023 оны стратеги төлөвлөгөө;

5. МҮЗ-ийн 2023 оны цалин урамшууллын төсөв;

6. МҮЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож;

7. Үзэгдэл ашгийн талаар гаргасан шийдвэр танилцуулах;



2023 оны хувьцаа  
эзэмшигчдийн ээлжит  
хурал 2023.04.28

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн № 02-р тогтоолын "Хавсралт №2"



**“Э-ТРАНС ЛОЖИСТИК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

Хурал 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт эхэлнэ.

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	10:00-10:10
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	10:10-10:15
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10:15-10:25
4	<b>Хурлаар хэлэлцэх асуудлууд</b>	
	Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт	10:25-10:35
	Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан	10:35-10:45
	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах	10:45-10:55
	Компанийн 2023 оны стратеги төлөвлөгөөг батлах	10:55-11:05
	ТУЗ-ийн 2023 оны цалин урамшууллын төсөв батлах	11:05-11:15
	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	11:15-11:20
	Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах	11:20-11:25
5	Асуулт хариулт	11:25-11:35
6	Саналын хуудас бөглөх заавар өгөх	11:35-11:40
7	Санал хураалт	11:40-11:55
8	Хурлын завсарлага	11:55-12:00
9	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	12:00-12:05
10	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	12:05-12:15
11	Хурлыг хаах (хурлын дарга)	12:15-12:20



## *Хэлэлцэх асуудал 1*

*Компанийн санхүүгийн  
тайлан, түүнд хийгдсэн  
аудитын дүгнэлт*





**“ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ” ХХК**  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АУДИТ БИЗНЭС ЗӨВӨЛГӨӨ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Төмөрчний гудамж,  
2 дугаар хороо, Тэнхстэг зууч төв, 1003 тоот  
Утас: (+976) 7000 – 1778, Утас: (+976) 7000 – 1778,  
И-мэйл: info@imkaudit.mn, Веб хуудас: www.imkaudit.mn

2023.04.10 № Д/2023/18

Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

**ХАРААТ БУС АУДИТОРЫН  
ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Бид Э-Транс ложистикс ХК (цаашид “Компани”гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шударгаар толилуулсан байна гэж дүгнэж байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

**Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

**Аудиторын үүрэг хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг

зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцооллыг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

#### **Хэрэглээний хязгаарлалт**

Энэхүү тайлан нь Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

#### **Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан**

Түүнчлэн, санхүүгийн тайланг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн Сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн заавартай нийцүүлсэн байна.

**ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК**

Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2023 оны 04 дүгээр сарын 10



## Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

### 1 Компанийн талаарх мэдээлэл

Э-Транс ложистикс ХХК нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу 2007 онд байгуулагдсан, 2010 онд Э-Транс ложистикс ХХК-д ачаа шилжүүлэн ачуулах терминалаа шилжүүлсэн Э-Транс ложистикс ХХК нь 2011 оны 12 дугаар сарын 06-ны өдөр нээлттэй хувьцаа гаргах хувьцаат компани болсон.

Компанийн хаяг: Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1 дүгээр баг, Төмөр замчдын өргөн чөлөө гудамж, 04-411 тоот Э-Транс ложистикс ХК-ийн байр. Утас: 02524543813

Компанийн улсын бүртгэлийн дугаар: 0610001001, Регистр: 3309665.

Э-Транс ложистикс ХК нь Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” болон Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, үндэсний холбогдох стандартын дагуу 3 жилийн хугацаатайгаар “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ”

КОД:0-2 Дагнасан хэрэглээний зам талбайн тусгай зөвшөөрлийг авсан.

Э-Транс ложистикс ХК нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд “Ачаа шилжүүлэн ачих” болон “Гадаад худалдаа” эрхлэхээр бүртгүүлсэн бөгөөд 2016 онд компанийн шинэчлэгдсэн дүрэмд дараах үйл ажиллагааг эрхлэхээр заасан байна. Үүнд

- Ачаа шилжүүлэн ачих
- Гадаад, дотоод худалдаа
- Компанийн тухай хууль, эрх зүйн зохицуулалтуудын хүрээнд бусад үйл ажиллагааг гүйцэтгэх бөгөөд Монгол Улсын хуулийн дагуу эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллана гэж заасан байна.

Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 4,620,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Хувьцааны тоо ширхэг болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

Хувьцаа эзэмшигчдийн	Хувьцааны эзэмшил					
	2021 он		2022 он			
Нэр	Аж ахуйн нэгж иргэний тоо	Татвар төлөгчийн дугаар	Тоо	Хувь	Тоо	Хувь
Э Транс ХХК	1	2546485	23,100,000.00	50.00	23,100,000.00	50.00
Би Ди Сек	1	2052482	13,179,669.00	28.53	13,725,020.00	29.71
Тасган инвест	1	6319238	5,092,835.00	11.02	5,102,298.00	11.04
ZWAHR ALEXANDER	1	7105188M	-	-	1,698,217.00	3.68
Би Ди Пи Эй Эф	1	6439349	1,818,857.00	3.94	1,284,457.00	2.78
Бусад аж ахуйн нэгж	18	-	1,323,654.00	2.87	66,482.00	0.14
Монгол Улсын иргэн	325	-	818,598.00	1.77	862,964.00	1.87
Бусад гадаадын иргэн	17	-	866,387.00	1.88	360,562.00	0.78
<b>НИЙТ ДҮН</b>	<b>363</b>	<b>-</b>	<b>46,200,000.00</b>	<b>100.00</b>	<b>46,200,000.00</b>	<b>100.00</b>

### 2 Компанийн үйл ажиллагааны орчин

Монгол улсын эдийн засаг нь хөгжиж байгаа эдийн засаг юм. Энэ нь тус улсын эдийн засгийн нөхцөл байдал нь зэсийн болон нүүрсний үнээс ихээхэн хамааралтай. Хууль эрх зүй, татварын зохицуулалтын орчин үргэлжлэн хөгжиж, байнга өөрчлөгдөж, холбогдох журам заавар өөрчлөгдөж байна.

Монгол Улсын татвар, валютын ханш, гаалийн хууль тогтоомж тогтвортой хэдий ч, гадаад худалдааны нөхцөл хурдтай хувирч байна. Монгол Улсын эдийн засгийн цаашдын гүйцэтгэл нь БНХАУ-ын эрэлтийн тасралтгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тогтворгүй байдал зэрэгтэй шууд холбоотой бөгөөд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй эдийн засаг, санхүү, мөнгөний арга хэмжээний үр нөлөө, татвар, хууль эрх зүйн зохицуулалт, улс төрийн үйл явцаас хамаарна. Дэлхийн эдийн засгийн өнөөгийн тодорхойгүй байдал, санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тогтворгүй байдал, Монголын эдийн засгийн өсөлт удааших, төгрөгийн ам.доллар, юаньтай харьцах ханшийн сулрал болон бусад болзошгүй эрсдэлүүд нь Монгол улсын болон компанийн санхүүгийн нөхцөлд ихээхэн сөрөг нөлөө

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөнд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан үедээ өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрдөг. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

#### 6.10.11 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Болзошгүй өр төлбөрүүд нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулдаг. Харин ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг компани хүртэх магадлалтай болсон үед санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулна.

#### 6.10.12 Холбоотой талууд

Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

- a) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
  - i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
  - ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
  - iii) Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- b) Дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:
  - i) Аж ахуй нэгж болон Компани нь нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусалтайгаа холбоотой).
  - ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
  - iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
  - iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
  - v) Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
  - vi) Аж ахуй нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
  - vii) (а) (i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
  - viii) Аж ахуй нэгж нь эсвэл Компанийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай.

#### 7 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө данс нь дараах үлдэгдэлтэй байна.

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Касс дахь бэлэн мөнгө	124,620,547.28	286,013,720.70
Харилцах дахь мөнгө	112,725,863.49	15,819,945.56
Дүн	237,346,410.77	301,833,666.26
1.1 Касс дахь бэлэн мөнгө (Мянган төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Төгрөг	124,620,547.28	286,013,720.70
Дүн	124,620,547.28	286,013,720.70
1.2 Банкин дах харилцах данс (валютаар)	2021.12.31	2022.12.31
Төгрөг MNT	112,725,863.49	15,819,945.56
Ам доллар USD	-	-
Дүн	112,725,863.49	15,819,945.56

## Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

**8 Дансны авлага болон бусад авлага**

Дансны авлагын хураангуй дараах байдалтай байна.

(төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Дансны авлага	4,762,617.15	16,241,701.84
Найдваргүй авлагын эрсдлийн сан	-	-
Дүн	4,762,617.15	16,241,701.84

Компани нь 2022 онд СТОУС 9 буюу санхүүгийн хөрөнгийн бүртгэх тайлагнах стандартыг хэрэгжүүлсэн. Найдваргүй авлагын эрсдлийн сан байгуулаагүй.

Борлуулалтын авлагын насжилтыг хоногоор дараах байдлаар харуулав.

**9 Бараа материал**

Бараа материал дансны хураангуй дараах байдалтай байна. Компани нь тайлант үеийн эцэст бараа материалын тооллогыг хийж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийг авч үзэн өртгөөр нь илэрхийлсэн.

(Мянган төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Түүхий эд материал		9,718,125.63
Бэлэн бүтээгдэхүүн	4,275,910.55	4,275,910.54
Бараа	11,125,138.64	11,125,138.64
Хангамжийн материал	35,060,527.63	39,406,536.73
Дүн	50,461,576.82	64,525,711.54

**10 Урьдчилж төлсөн зардал тооцоо**

**11 Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани биет бус хөрөнгийн хорогдлыг өмнөх жилийн үлдэх өртгөөс шууд хасаж тайлант оны зардалаар хүлээн зөвшөөрдөг.

(Төгрөгөөр)	Программ хангамж	Газар эзэмших эрх	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
2021.12.31-ний үлдэгдэл	5,220,295.04	386,659,353.56	9,376,163.67	401,255,812.27
Нэмэгдсэн	3,000,000.00	-	7,500,000.00	10,500,000.00
Хорогдуулсан	2,435,375.08	57,692,304.72	7,229,742.96	67,357,422.76
2022.12.31-ний үлдэгдэл	5,784,919.96	328,967,048.84	9,646,420.71	344,398,389.51

**Аудитлагдсан санхүүгийн тайлангаас**

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК  
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

12 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани нь үндсэн хөрөнгөө дахин үнэлгээний загвар ашиглан бүртгэсэн, хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

<i>(тогrog)</i>	Барилга байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Компьютер дагалдах хэрэгсэл	Нийт дүн
<b>ӨРТӨГ</b>						
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,448,792,606.70	473,591,978.88	376,190,115.62	82,769,012.64	77,136,145.00	6,458,479,858.84
Өөрөө үйлдвэрлэсэн	-	-	-	-	-	-
Худалдаж авсан	125,681,818.18	25,346,727.27	-	1,917,909.09	6,029,931.82	158,976,386.36
Акталсан	-	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,574,474,424.88	498,938,706.15	376,190,115.62	84,686,921.73	83,166,076.82	6,617,456,245.20
<b>ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ</b>						
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,299,553,729.19	341,270,987.14	279,681,173.30	54,389,567.30	70,012,140.38	2,044,907,597.31
Байгуулсан элэгдэл	160,717,542.84	22,738,236.38	22,728,835.81	6,059,444.13	5,000,239.87	217,244,299.03
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	-	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,460,271,272.03	364,009,223.52	302,410,009.11	60,449,011.43	75,012,380.25	2,262,151,896.34
<b>ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН</b>						
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,149,238,877.51	132,320,991.73	96,508,942.32	28,379,445.34	7,124,004.62	4,413,572,261.52
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,114,203,152.85	134,929,482.63	73,780,106.51	24,237,910.30	8,153,696.57	4,355,304,348.86

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр компани өөрийн бараа материал, тоног төхөөрөмж мөн барилга, байгууламж зэргийг барьцаалсан мэдээлэл байхгүй байна.

Аудитлагдсан санхүүгийн  
тайлангаас

### 13 Дансны болон бусад өглөг

#### 13.1 Дансны өглөг

Дансны өглөг дансны хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Худалдан авалтын төлбөрийн өглөг	4,410,000.00	1,284,676.76
<b>Дүн</b>	<b>4,410,000.00</b>	<b>1,284,676.76</b>

#### 13.2 Бусад өглөг

Бусад өглөг дансны хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Худалдан авалтын өглөг	11,818,182.80	11,818,182.80
<b>Дүн</b>	<b>11,818,182.80</b>	<b>11,818,182.80</b>

### 14 Урьдчилж орсон орлого

Компани нь бүтээгдэхүүн хүргэлттэй уялдуулан тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрдөг. Жил бүр дараагийн тайлант хугацаанд ногдох орлогыг богино хугацаат урьдчилж орсон орлогын дансанд бүртгэн тайлагнасан.

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Урьдчилж орсон орлого-Түрээсийн орлого	500,000.00	5,517,000.00
<b>Дүн</b>	<b>500,000.00</b>	<b>5,517,000.00</b>

Урьдчилж орсон орлогын мэдээллийг харилцагчийн байдлаар авч үзвэл дараах байдалтай байна.

### 15 Нөөц өр төлбөр

Нөөц өр төлбөр байгуулаагүй, үлдэгдэлгүй байна.

### 16 Татварын өглөг

Татварын өглөгийн хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Аж ахуй нэгжийн орлогын албан татварын өглөг	2,275,603.13	4,950,326.29
Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг	8965356.48	24,944,438.54
Хувь хүний орлогын албан татварын өглөг	26,494,711.54	19,744,003.33
<b>Дүн</b>	<b>37,735,671.15</b>	<b>49,638,768.16</b>

## Аудитлагдсан санхүүгийн тайлангаас



#### 17 Орлогын татварын зардал

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилд орлогын албан татвар дараах байдалтай байна:

(төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Татвар төлөхийн өмнөх ашиг	293,073,228.26	30,992,987.50
Тусгай орлого	2,954,694.05	-
Хасагдахгүй зардал	11,012,342.55	24,566,422.00
Байнгын зөрүүгээр зохицуулагдах	301,130,876.76	55,559,409.50
Татварын түр зөрүү	-	-
Ханшийн болитг бүс олз	(69.76)	56,146.63
Хэрэгжсэн олз	909,090.91	-
Түр зөрүүгээр зохицуулагдсан	302,039,897.91	55,503,262.87
Нийтлэг хувь хэмжээгээр суутгуулсан татвар	30,113,087.12	5,550,326.29
Тусгай хувь хэмжээгээр суутгуулсан	295,469.12	-

2020 оноос хэрэгжиж байгаа ААНОАТ-ын шинэ хуулийн дагуу тайлант үеийн Орлогын албан татварыг 10 хувиар ногдуулсан.

Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх тайлбар болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь татварын аливаа асуудал үүсэж байгаагүй ажил гүйлгээ, үйл ажиллагаанд татварын аливаа асуудал үүсэхийг үгүйсгэхгүй юм. Үүний үр дүнд нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийх тайлант жилээс өмнөх 4 жилийн хугацааг хамарч болно. Зарим тухайлсан тохиолдолд түүнээс ч урт хугацааг хамарч болно.

Үнэ шилжилттэй холбоотой Монгол Улсын хуулийн заалтууд нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба тодорхой онцлог шинж чанарыг агуулсан ч Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас боловсруулсан олон улсын үнэ шилжилттэй холбоотой зарчимд ерөнхийдөө суурилсан. Үнэ шилжилттэй холбоотой хуулийн зохицуулалт нь тухайн байгууллагын хяналтад байгаа ажил гүйлгээнүүд (холбоотой талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ, мөн зарим холбоогүй талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ) хэрэв сунгасан гарын зарчмаар хэрэгжээгүй бол татварын аливаа эрсдэл үүсэх зохицуулалттай. Удирдлага нь одоогийн үнэ шилжилттэй холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх төлөвлөгөө, журмыг хэрэгжүүлж байгаа.

#### 18 Эдийн өмч

Хувьцаат капитал нь тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн	Хувьцааны эзэмшил			
	2021 он		2022 он	
Нэр	Дүн	Хувь	Дүн	Хувь
Э Транс ХХК	2,310,000,000.00	50	2,310,000,000.00	50
Би Ди Сек	1,317,966,900.00	28.53	1,372,502,000.00	29.71
Тасган инвест	509,283,500.00	11.02	510,229,800.00	11.04
ZWANR ALEXANDER	-	-	169,821,700.00	3.68
Би Ди Пи Эй Эф	181,885,700.00	3.94	128,445,700.00	2.78
Бусад аж ахуйн нэгж	132,365,400.00	2.87	6,648,200.00	0.14
Монгол Улсын иргэн	81,859,800.00	1.77	86,296,400.00	1.87
Бусад гадаадын иргэн	86,638,700.00	1.88	36,056,200.00	0.78
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4,620,000,000.00</b>	<b>100</b>	<b>4,620,000,000.00</b>	<b>100</b>

## Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК  
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Компанийн дүрмийн сан нь тайлант хугацааны эцэст нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй  
46,200,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

Компанийн хуримтлагдсан ашгийн данс нь дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	Тайлан жилийн дүн
2021.12.31-ний үлдэгдэл	(450,177,872.88)
Хуваарилсан ногдол ашиг	(46,200,000.00)
Орлогын албан татварын буцаалт	27,070,563.86
Тайлант жилийн цэвэр ашгаар нэмэгдсэн	25,442,661.21
2022.12.31-ний үлдэгдэл	(443,864,647.81)

#### 19 Орлого

Борлуулалтын орлого дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Ачилтын орлого	96,913,600.00	24,716,727.27
Хадгалалтын орлого-гарах хуудасны орлого	752,232,000.00	456,068,499.99
Баталгаат агуулахын орлого	485,250,300.00	460,532,634.55
Бусад үйлчилгээний орлого	82,254,010.00	278,872,500.00
Түрээсийн орлого	57,818,181.82	41,242,726.73
<b>Дүн</b>	<b>1,474,468,091.82</b>	<b>1,261,433,088.54</b>

#### 20 Борлуулалтын өртөг

Борлуулалтын өртөг дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2021	2022
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 21 Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардал дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Борлуулалт маркетингийн зардал	1,174,246,235.61	1,205,929,825.67
<b>Дүн</b>	<b>1,174,246,235.61</b>	<b>1,205,929,825.67</b>

#### 21.1 Бусад зардал

Бусад зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Тэтгэмжийн зардал	11,012,342.55	1,600,000.00
Алданги торгуулийн зардал	-	8,150,866.00
Хөрөнгө ахталж устгасны зардал	909,090.91	-
Бусад зардал	-	14,815,556.00
<b>Дүн</b>	<b>11,921,433.46</b>	<b>24,566,422.00</b>

## Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

## 22 Бусад ашиг, алдагдал

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Гадаад валютын ханшийн зөрүүний ашиг	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал	(69.76)	56,146.63
<b>Дүн</b>	<b>(69.76)</b>	<b>56,146.63</b>

## 23 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Компанийн удирдлага нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Түүнчлэн Компанийн удирдлага нь эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаа өдөр тутам хийгдэж байгаа эсэхэд үүрэг хариуцлага хүлээдэг. Удирдлага нь хувьцаа эзэмшигчдэд үйл ажиллагааныхаа талаар тайлагнадаг.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон систем нь зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд гарч байгаа аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд байнгын хяналт сайжруулалтын дор байдаг. Компани нь өөрийн сургалт, удирдлагын стандарт болон дүрэм журмаараа дамжуулан ажилтнууд өөрсдийн үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарласан байх зохион байгуулалт бүхий, бүтээлч хяналт бүхий орчныг бий болгохоор зорин ажилладаг.

Э-Транс ложистике ХК нь зээлийн болон бусад эрсдэлийн удирдлагаар хангах үүрэгтэй бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай буюу тодорхой түвшинээс дээших хэмжээний томоохон хэлцлүүдийг хянан үзэх байдлаар ажилладаг. Мөн түүнчлэн худалдан авалт болон борлуулалтын урт хугацаатай гэрээ, хэлцэл болон капитал хөрөнгө оруулалт, зээл зэрэг харьцангуй төвөгтэй урт хугацааны шинжтэй хэлцлүүдэд хэлэлцээр хийх болон зохион байгуулалтыг Хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцэн шийдвэр гаргадаг.

### 23.1 Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь санхүүгийн өр төлбөртэй хамаарал бүхий үүрэг хариуцлагаа биелүүлэхэд компанид тулгарч болох аливаа хүндрэлүүд юм. Компанийн төлбөрийн чадвараа удирдах арга хандлага нь өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах хангалттай төлбөрийн чадвартай байх, үл хүлээн зөвшөөрөгдөх аливаа алдагдлыг хүлээхгүй байх.

Дараах хүснэгтээрх мэдээлэл нь компанийн санхүүгийн өр төлбөрийг төлөхөд бэлэн байдал, түүнийг төлөх нөөцийн боломжийг харуулна.

(Төгрөгөөр)	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн хөрөнгө	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	237,346,410.76	301,833,666.26
Дансны авлага болон бусад авлага	5,564,435.33	20,241,701.84
<b>Дүн</b>	<b>242,910,846.09</b>	<b>322,075,368.10</b>
Санхүүгийн өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр	17,378,182.80	17,378,182.80
Татварын өглөг	37,469,748.69	37,469,748.69
Урт хугацаат өр төлбөр	0.00	-
<b>Дүн</b>	<b>54,847,931.49</b>	<b>54,847,931.49</b>

### 23.2 Валютын ханшийн эрсдэл

Компани өөрийн үйл ажиллагааны валют болох төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн борлуулалт, худалдан авалт, зээлд гадаад валютын ханшийн эрсдэлийг хүлээдэг. Эдгээр ажил гүйлгээний илэрхийлэгдсэн үндсэн валют нь Америкийн доллар юм. Компани валютын ханшийн

## Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

эрсдэлээс зайлсхийхийн тулд гадаад валютын хэлбэлзлийг тогтмол хянаж, ирээдүйн гадаад валютын мөнгөн урсгалаа удирддаг.

Тайлант жилийн эцэс дэх Монгол банкны хаалтын ханшийг дор үзүүлэв.

Мөнгөн тэмдэгт	2021.12.31 (төгрөг, мөнгөөр)	2022.12.31 (төгрөг, мөнгөөр)	Хэлбэлзэл /+/-
Ам.Доллар	2,849.89	3,444.60	594.71
Юань	446.96	495.40	48.44

### 23.3 Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл нь голдуу хөвөгч хүүтэй хадгаламж, зээлд тохиолдож болох хүүгийн түвшний ирээдүйд гарах өөрчлөлтийн хэлбэлзлийн эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдэлийн удирдлагын зорилго нь санхүүгийн зардлыг хамгийн бага байлгах болон хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой тодорхой бус байдлыг бууруулахад чиглэдэг. Хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотойгоор хүлээх зах зээлийн эрсдэл нь голдуу Компанийн зээлтэй хамааралтай байдаг.

### 23.4 Үйл ажиллагааны эрсдэл

Компанийн санхүүгийн удирдлагын бодлого болон зарчим нь компанийн зээлжих дээд хязгаар, капиталын бүтэц, эргэлтийн хөрөнгийн удирдлага, хөрвөх чадварууд дээр санхүүгийн харьцаануудын зохистой түвшинг тогтоох замаар санхүүгийн болон үйл ажиллагааны шилдэг арга туршлагыг нэвтрүүлэхийг зорилго болгодог байна. Мөн түүнчлэн зорилтот ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшинг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал болон зорилтот салбарын онцлогийг харгалзан үздэг.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд Компанийн хөрөнгө оруулалт болон тогтоосон санхүүгийн харьцаануудыг тодорхой түвшинд хангаж байх хэмжээнд өөрсдийн бизнесийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны төсвийг боловсруулж, хэлэлцэн хэрэгжүүлдэг. Түүнчлэн, санхүүгийн харьцаануудын гүйцэтгэлийн биелэлт нь жилийн гүйцэтгэлийн үнэлгээний системд багтсан ба гүйцэтгэх удирдлагын багийн гүйцэтгэлийн үнэлгээ болон тэдний цалингийн хувьсах бүрэлдэхүүн хэсэгт (урамшуулал цалин) чухал ач холбогдолтой. Компанийн санхүүгийн удирдлагад ашиглагддаг хамгийн түгээмэл санхүүгийн харьцаанууд нь:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа = Эргэлтийн хөрөнгө/Богино хугацаат өр төлбөр;
- Зээл/Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг (ХТЭХӨА);
- Эргэцийн харьцаа, хоног (авлага, бараа материал болон өглөг);
- Зээлийн үйлчилгээ хийх чадварын харьцаа = Чөлөөт мөнгөн урсгал/Зээлийн үйлчилгээний дүн;
- Өгөөжийн дотоод норм;
- Ашигт ажиллагааны зорилтот түвшин: ХТЭХӨА маржин, татварын дараах ашгийн маржин.

Э-Транс ложистикс ХК нь зорилтот хөрөнгө оруулалтын өгөөжийг бий болгохын зэрэгцээ, компанийн хэмжээнд эрсдэлийг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд эрсдэлийн иж бүрэн цогц удирдлагын системийг бий болгохоор зорин ажиллаж байна.

## 24 Капиталын удирдлага

Компанийн капиталд хөрөнгө удирдлагын зорилгоор, хөрвөх нөхцөлтэй хувьцаа, хувьцааны урамшуулал болон эздийн өмчид хуваарилагдах бусад бүх капиталын нөөцийг оруулна. Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих ба хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Компанийн өрийг өмчид харьцуулсан харьцааг тайлант хугацааны эцэст илэрхийлбэл:

(Мянган төгрөгөөр, өрийн харьцаанаас бусдаар)	2020.12.31	2021.12.31
---	------------	------------

## Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК  
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Нийт өр*	159,884,690.01	54,847,931.49
Нийт эздийн өмч	5,067,015,535.53	5,098,680,207.25
Өрийн харьцаа	3.10%	1.10%

### 25 Холбоотой талууд

#### 25.1 Хувьцаа эзэмшигчид болон компанийн удирдлага

Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд холбоотой талуудын хамаарал болон хийгдсэн ажил гүйлгээ байдалтай байна.

#### 25.2 Холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ:

Ногдол ашигтай холбоотой ажил гүйлгээ.

Хувьцаа эзэмшигчид	Харьяалал	Харилцан хамаарал	Холбоотой гүйлгээ
Э-Транс ХХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
Би Ди Сек ХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
Тасган инвест ХХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
Би Ди Пи Эй Эф ХХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
Бусад	Иргэд, аж ахуйн нэгж	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг

#### 25.3 Бусад холбоотой талууд

Бусад холбоотой талуудад хувьцаа эзэмшигчид болон тэдний гэр бүлийн гишүүд болон гишүүдтэй холбоотой байгууллагууд, компанитай адил нэг захирал эсвэл гол удирдлагатай байгууллагууд, захирал болон гол удирдлага мөн тэдгээрийн гэр бүлийнхэнтэй холбоотой байгууллагууд хамаарна.

### 26 Үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс

#### 26.1 Хууль, эрх зүй

Компани нь бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад ч хуулийн аливаа зарга маргаан болон гомдолтой холбогдож болно. Хэрэв аливаа зарга маргаан, гомдол гарснаас ямар нэгэн үүрэг хариуцлага үүсвэл энэ нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна.

#### 26.2 Байгууллагын үйл ажиллагаа, эдийн засгийн нөлөө

2022 онд БНХАУ гарсан цар тахлын нөлөөгөөр хилийн нөхцөл байдал хаалттай хилээр орж ирж байгаа импортын ачаа бараа хязгаарлалттай байснаас нь компанийн үйл ажиллагааг тодорхой хэмжээгээр зогсонги байдалтай байлгасан. Тухайн нөхцөл байдалд үйл ажиллагаагаа бүрэн зогсоох хэмжээнд хүргэхгүйн тулд гүйцэтгэх удирдлагаас шилжүүлэн ажиллагааг өөрийн техник тоног төхөөрөмж, талбайг ашиглан чингэлэг болон bigbag савлагаатай ачааг буулган, хадгалах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр яриа хэлэлцээр хийсний үр дүнд 2-3 компанитай энэ чиглэлд ажил үйлчилгээ зохион байгуулж ажилласан.

Салбар замаар 2022 онд 50 вагон ачааг шилжүүлэн авчсан нь өмнөх оны мөн үеэс даруй 294 вагоноор буурсан мөн гаалийн хяналтын бүсэд орж ирсэн тээврийн хэрэгсэл, ачаа бараа 2021 онд 14677 орж ирж байсан бол 2022 онд 6489 болж 8188-ээр буурсан зэрэг сөрөг үзүүлэлттэй жил болсон байна.

Өмнө жилүүдэд удаан хугацаагаар хадгалалтад байсан техник тоног төхөөрөмжүүд гарснаар хадгалалтын орлого тодорхой хэмжээгээр мөн буурсан үзүүдэлтгэй байна. Хилийн нөхцөл байдалтай хүндрэлтэй байснаас шалтгаалан компанийн үйл ажиллагаа доголдолтой байсан ч үндсэн үйл ажиллагаагаа бүрэн зогсоолгүй тодорхой гарц гаргалгааг олж зарим ажлуудыг зохион байгуулж ажилласнаар санхүүгийн хувьд алдагдалгүй ажиллаж татварын дараах цэвэр ашиг 25,442,661.21 төгрөг гарсан.

Жилийн стратеги төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг дүгнэж үзэхэд өөрсдийн нөхцөл бололцоонд түшиглэн гаалийн хяналтын бүсээ MNS 5832.2007 стандартад нийцүүлж зам талбайг засах ажлыг хийж гүйцэтгэн өнөөдрийн байдлаар нийт 231,583,000 төгрөгийн хавтангаар 3552м<sup>2</sup> талбайг хучиж янзалсан, гаалийн байгууллагаас шаардсаны дагуу гаалийн хяналтын бүс дэх гаалийн камерын хяналтыг сайжруулах үүнтэй уялдан өөрсдийн камерын хяналтын тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнээс гадна компанийн веб хуудсыг шинэчлэн хэрэглэгчдэд илүү ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллийг хүргэж ажиллаж байгаа бөгөөд цаашид өөрийн үйл ажиллагааг цахимжуулах нөхцөл бололцоог судалж 2023 онд гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг цахимд шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх, шинээр хүнд даацын автокран авах ажлыг өөрийн нөхцөл бололцоонд тулгуурлан зохион байгуулах, өмнөх жилүүдэд хийхээр төлөвлөсөн ч цар тахалтай холбоотойгоор хойшлогдоод байсан ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

#### 27 Тайлангийн дараах үйл явдал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор Э-Транс Ложистикс ХК-ийн 2022 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 46 хувь буюу нэгж хувьцаанд 3 төгрөгөөр тооцон 46,200,000 ширхэг хувьцаанд нийт 138,600,000.00 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Удирдлага нь санхүүгийн тайланд нөлөөлөхүйц тайлант хугацааны дараа гарсан бусад үйл явдал байхгүй гэж үзэж байна.

**ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК**

Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2023 оны 04 дүгээр сарын 10



## Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

## *Хэлэлцэх асуудал 2*

*Компанийн 2022 оны  
үйл ажиллагааны  
тайлан*



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2022 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

2023.03.13

Борхойн тал

<b>Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/</b>	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 12 дугаар сарын 31
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Э-Транс ложистикс ХК, ETR, 99117636
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	46,200,000 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа
<b>1.</b>	<b>Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</b>



Санхүүгийн байдлын үзүүлэлт	<p>Эргэлтийн хөрөнгийн дүн - <b>473,549,321.68</b>  Эргэлтийн бус хөрөнгийн дүн - <b>4,699,702,738.37</b>  Нийт хөрөнгийн дүн - <b>5,173,252,060.05</b>  Богино хугацаат өр төлбөрийн дүн - <b>68,258,627.73</b>  Өр төлбөрийн нийт дүн - <b>68,258,627.73</b>  Эзэмшигчдийн өмчийн дүн - <b>5,104,993,432.32</b>  Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн - <b>5,173,252,060.05</b></p>
Орлогын тайлан	<p>Борлуулалтын орлого (цэвэр) - <b>1,220,160,361.81</b>  Нийт ашиг (алдагдал) - <b>1,220,160,361.81</b>  Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) - <b>30,992,987.50</b>  Татварын дараах ашиг (алдагдал) - <b>25,442,661.21</b>  Нийт орлогын дүн - <b>25,442,661.21</b></p>
Өмчийн өөрчлөлтийн тайлан	<p>Өмч - <b>4,620,000,000.13</b>  Нэмж төлөгдсөн капитал - <b>154,000,000.00</b>  Эздийн өмчийн бусад хэсэг - <b>774,858,080.00</b>  Хуримтлагдсан ашиг - <b>(443,86,647.81)</b>  Нийт дүн - <b>5,104,993,432.32</b></p>
Мөнгөн гүйлгээний тайлан	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>
	<p>Мөнгөн орлогын дүн (+) - <b>1,420,392,298.18</b>  Мөнгөн зарлага (-) - <b>1,082,299,603.42</b>  Цэвэр мөнгөн гүйлгээ - <b>338,092,694.76</b></p>
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>
	<p>Мөнгөн орлогын дүн (+) - <b>300,262.90</b>  Мөнгөн зардагын дүн (-) - <b>232,483,930.00</b>  Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн - <b>(232,183,667.10)</b></p>
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>
	<p>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн - <b>(41,421,772.15)</b>  Бүх цэвэр мөнгөн гүйлгээ - <b>64,487,255.51</b>  Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл - <b>301,833,666.26</b></p>

2.1.	<b>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</b>
	<p>2022 онд БНХАУ гарсан цар тахлын нөлөөгөөр хилийн нөхцөл байдал хаалттай хилээр орж ирж байгаа импортын ачаа бараа хязгаарлалттай байсан нь компанийн үйл ажиллагааг тодорхой хэмжээгээр зогсонго байдалтай байлгасан. Тухайн нөхцөл байдалд үйл ажиллагаагаа бүрэн зогсоох хэмжээнд хүргэхгүйн тулд гүйцэтгэх удирдлагаас шилжүүлэн ачилтыг өөрийн техник тоног төхөөрөмж, талбайг ашиглан чингэлэг болон bigbag савалгаатай ачааг буулган, хадгалах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр яриа хэлэлцээр хийсний үр дүнд 2-3 компанитай энэ чиглэлд ажил үйлчилгээ зохион байгуулж ажилласан. Салбар замаар 2022 онд 50 вагон ачааг шилжүүлэн авчсан нь өмнөх оны мөн үеэс даруй 294 вагоноор буурсан мөн гаалийн хяналтын бүсэд орж ирсэн тээврийн хэрэгсэл, ачаа бараа 2021 онд 14677 орж ирж байсан бол 2022 онд 6489 болж 8188-ээр буурсан зэрэг сөрөг үзүүлэлттэй жил болсон байна. Салбар зам дахь шилжүүлэн ажилт ерөнхийдөө бүрэн зогссон байдалтай байсан тул УБТЗ-аас салбар зам ашиглан Хятад улсаар орж ирж байгаа задгай ачааг мөн өөрийн техник тоног төхөөрөмж, хүн хүчийг ашиглан засаж янзлах, жин тонныг тэнцүүлэх хүсэлт ирүүлснийг ажил хэрэг болгосны дүнд вагоны даац хэтрэлт, ачааг засаж янзлах ажлаас 112,6 сая төгрөгийн ашигтай ажил гүйцэтгэсэн. Өмнө жилүүдэд удаан хугацаагаар хадгалалтанд байсан техник тоног төхөөрөмжүүд гарснаар хадгалалтын орлого тодорхой хэмжээгээр мөн буурсан үзүүлэлттэй байна. Хилийн нөхцөл байдалтай хүндрэлтэй байснаас шалтгаалан компанийн үйл ажиллагаа доголдолтой байсан ч үндсэн үйл ажиллагаагаа бүрэн зогсоолгүй тодорхой гарц гаргалгааг олж зарим ажлуудыг зохион байгуулж ажилласнаар санхүүгийн хувьд алдагдалгүй ажиллаж татварын дараах цэвэр ашиг 25,442,661 төгрөг гарсан. Жилийн стратеги төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг дүгнэж үзэхэд өөрсдийн нөхцөл бололцоонд түшиглэн гаалийн хяналтын бүсээ MNS 5832:2007 стандартад нийцүүлж зам талбайг засах ажлыг хийж гүйцэтгэн өнөөдрийн байдлаар нийт 231,583,000 төгрөгийн хавтангаар 3552м<sup>2</sup> талбайг хучиж янзалсан, гаалийн байгууллагаас шаардсаны дагуу гаалийн хяналтын бүс дэх гаалийн камерын хяналтыг сайжруулах үүнтэй уялдан өөрсдийн камерын хяналтын тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнээс гадна компанийн веб хуудсыг шинэчлэн хэрэглэгчдэд илүү ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллийг хүргэж ажиллаж байгаа бөгөөд цаашид өөрийн үйл ажиллагааг цахимжуулах нөхцөл бололцоог судлаж 2023 онд гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг цахимд шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх, шинээр хүнд даацын автокран авах ажлыг өөрийн нөхцөл бололцоонд тулгуурлан зохион байгуулах, өмнөх жилүүдэд хийхээр төлөвлөсөн ч цар тахалтай холбоотойгоор хойшлогдоод байсан ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.</p>

д/д	Орлогын нэр	2021 он	2022 он	Зөрүү	Өсөлт бууралт
1	Ачилтын орлого	96,913.61	50,013.90	-46,899.71	(93.77)
2	Хадгалалт болон гарах хуудас	1,237,482.33	916,600.8	-320,881.53	(35.01)
3	Түрээсийн орлого	57,818.18	47,727.2	-10,090.98	(21.14)
4	Бусад орлого	85,822.27	247,091.10	161,268.83	1.87 дахин өссөн

**2.2.** **Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц,  
боломжийн үзүүлэлт**

<b>Хөрөнгийн байдлын үнэлгээ</b>		
<b>Төрөл</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Дүгнэлт</b>
	2022 он	
Хөрөнгийн өсөлтийн хурд	98.67%	Нийт хөрөнгөнд өсөлт үзүүлэхүйц өөрчлөлт хийгдээгүй байгаа хөрөнгөнд элэгдлээр буурч байгаа байдлаас үзэхэд дийлэнх хөрөнгө ашиглах хугацаа урт хөрөнгүүд байна.
Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	6.56%	Эргэлтийн хөрөнгийн эзлэх жин өмнөх оноос 2%-р өссөн байгаа ч нийт хөрөнгийн 8.46%-г эзэлж байгаагаас дүгнэхэд хөрөнгийн хөрвөх чадвар муу ба нийт хөрөнгийн 91.5%-ийг үндсэн хөрөнгө эзлэж байна.
Элэгдлийн хувь		
<b>Санхүүгийн байдлын үнэлгээ</b>		
<b>Төрөл</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Дүгнэлт</b>
	2022 он	
Ажлын капитал	405,290,693.95	Ажлын капитал сайн ба ямар нэгэн өр төлбөрийн дарамтын эрдсэл бага байна.
Ажлын капиталын оролцоо	85.58%	Эргэлтийн хөрөнгийн 85.58% хувийг байнгын капиталаар санжүүжүүлж байна.
Эргэлтийн харьцаа	6.93	Эргэлтийн хөрөнгөөр БХӨТ-ийг барагдуулах чадвар сайн.
Бие даалтын коеф	98.68%	Бие даан үйл ажиллагаа явуулах чадвар өндөр.
<b>2.3.</b>	<b>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</b>	
	2022 оны хувьд БНХАУ-аас хилийн хорио цээрийн дэглэм хэрэгжиж хилээр орох импортын ачаа бараа хязгаарлагдмал зөвхөн чингэлэг тээврийн үйл ажиллагаа, шинэ тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж л тодорхой тоо хязгаартай тээвэрлэгдэж байсан. Чингэлэг тээврийн зарим хэсгийг өөрийн гаалийн хяналтын бүсээрээ дамжууланг авах талаар гаалийн байгууллагатай тохиролцоонд хүрсэн боловч техник хэрэгслийн байдлаас шалтгаалан энэхүү ажил зогссон. Харин шинээр орж ирж байгаа тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг өөрийн гаалийн хяналтын бүсээр дамжуулах, жин тонныг нь баталгаажуулах зэрэг ажлыг тодорхой хэмжээнд хийж гүйцэтгэж ажилласан.	



2.	Чулууны Энхболд	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
3.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Э-Транс Ложистикс ХК, Гүйцэтгэх захирал
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	60%	Би Ди Сек ХК, Тэргүүн дэд захирал
5.	Данзангийн Даянбилгүүн	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	60%	Би Ди Сек ХК, Гүйцэтгэх захирал
6.	Шараагийн Шинэбаяр	ТУЗ-ын хараат гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	80%	Би Ди Сек ХК, хөрөнгө оруулалтын менежер
7.	Хасагийн Бат-Эрдэнэ	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	80%	Интерсорс ХХК, Захирал
8.	Жаргалсайханы Энхтулга	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Лайф ис Гүүд Монголиа ХХК, нягтлан бодогч
9.	Чулуунбаатарын Оргил	ТУЗ-ын хараат бус гишүүн	Эзэмшдэггүй	Дээд	100%	Хувиараа

ТУЗ-ын даргаар Э.Батболд, аудитын хороонд Э.Батболд / дарга /, гишүүд Х.Бат-Эрдэнэ, Ч.Оргил, нэр дэвшүүлэх хороонд Х.Бат-Эрдэнэ / дарга /, гишүүд Ж.Энхтулга, Б.Лхагвадорж, цалин урамшууллын хороонд Д.Даянбилгүүн / дарга /, гишүүдэд Ч.Оргил, Ж.Энхтулга нар сонгогдон ажиллаж байна.

Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний тайлан мэдээг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн холбогдох хэлтэст хүргүүлж үнэлүүлсэн бөгөөд 95,8 хувь буюу Засаглал хэвийн буюу Эрсдэлгүй гэж үнэлүүлсэн байна. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд компанид мөрдөгдөвөл зохих 8

	дүрэм, журмыг боловсруулан ТУЗ-аар хэлэлцүүлэн баталгаажуулсан ба үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.				
	Компанийн удирдлагад өөрчлөлт ороогүй болно.				
	д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
	1.	Чулуун Амарсанаа	Гүйцэтгэх захирал	Дээд, уулын инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
	2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч, нягтлан бодогч	2011 оноос хойш ажиллаж байна.
	3.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
	4.	Ванданлхүндэв Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Дээд, Эрүүл ахуйч	2011 оноос хойш ажиллаж байна.
	5.	Содномцэрэн Ганбат	Дотоод ажил хариуцсан ажилтан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Дээд, хуульч цагдаагийн байгууллагын ажилтан	2014 оноос хойш ажиллаж байна.
<b>6.</b>	<b>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</b>				
	Тухайн бүс нутагт адил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудын өрсөлдөх чадамж нэмэгдэж байгаа нь тухайн компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх байдалтай байна. Өнөөдрийн байдлаар тус компанийн гаалийн хяналтын бүсээс гадна Дардан ложистикс ХХК-ны гаалийн хяналтын бүс, Бүс нутгийн ложистик төвийн гаалийн хяналтын бүсүүдэд голлох үйл ажиллагаа явагдаж байгаа ба компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтын хувьд УБТЗ-ын Замын-Үүд өртөө гол үйл ажиллагааг эрхэлж байгаа болно. Гол анхаарах зүйл но боомтын үйл ажиллагаа хэвийн ажиллаж эхэлсэн тохиолдолд гаалийн хяналтын бүс дэх хяналт шалгалтын ажил хилийн боомтдоо төвлөрч тус хяналтын бүсээр дамжих тээврийн хэрэгсэл, ачаа барааны тоо хэмжээ эрс багасах болгоомжлол байгаа бөгөөд энэхүү байдлаас урьдчилан сэргийлэх үүднээс шилжүүлэн ачилт, агуулахын хадгалалтын нөхцөл байдлаа дээшлүүлэх, шинэчлэл өөрчлөлт хийхээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хүнд даацын автокран авах ажлыг нэн даруй хийхээр төлөвлөж байгаа ба өөрсдийн санхүүгийн нөхцөл байдлыг сайжрахаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.				
<b>7.</b>	<b>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</b>				

	Тус компани нь нийт 363 хувьцаа эзэмшигчтэй, Э-Транс ХХК / нийт хувьцааны 50 % /, БиДиСек ХК / нийт хувьцааны 28,5% /, Тасган инвест ХХК / нийт хувьцааны 11,08% / эзэмшдэг 5%-иас дээш хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчидтэй.
<b>8.</b>	<b>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</b>
	Төсөл хэрэгжүүлэхээр хувьцаа гаргаагүй болно.
<b>9.</b>	<b>Ногдол ашгийн мэдээлэл</b>
	2021 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 төгрөг байхаар тооцож 46,200,000 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд тараахаар шийдвэрлэн 2022 оны 12 сарын 31-ний дотор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдэд тараасан болно. 2023 оны 02 сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ хурлын шийдвэрээр компанийн 2022 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийн 46 хувь буюу нэгж хувьцаанд 3 төгрөг байхаар тооцон 46,200,000 хувьцаанд нийт 138,600,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтоосон 01 тоот тогтоол гарсан. Тогтоолын дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ний дотор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг тараах болно.
<b>10.</b>	<b>Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</b>
	Тус компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд компанийн хариуцсан талбайн цэвэрлэгээ үйлчилгээг тогтоосон хугацаанд болон сумын Засаг даргын тамгын газар, Багийн Засаг даргын ирүүлсэн хүсэлтийн дагуу тогтмол цэвэрлэн байгаль орчны бохирдлоос сэргийлэх ажлыг зохион байгуулж байна. Сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу олон улсын чанартай замын буюу компанийн үйл ажиллагаа эрхэлж байгаа нутаг дэвсгэр дэх замын гэрэлтүүлгийн 15 гэрлийг шинээр сольсон бөгөөд үүнийг нарны зай хураагууртай гэрлээр шийдвэрлэлээ. Ажилчдыг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулан компанийн дотоод журамд заасны дагуу эрүүл мэндийн шалтгааны улмаас удаан хугацаагаар эмчлүүлж байгаа ажилтан, ар гэрийн гачигдал, гэр нь шатсан зэрэг нэг удаагийн буцалтгүй тусламж тэтгэмж олгохоор заагдсан тохиол бүрт гүйцэтгэх захирлын тушаалаар тусламж тэтгэмжийг олгож ажилласан байна. Хамтран ажиллагч байгууллага болох УБТЗ-ын Замын-Үүд өртөө, Замын-Үүд дэх гаалийн газар, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүд зэрэг байгууллагуудын түүхт ойн арга хэмжээнүүдэд оролцон нягт хамтран ажиллаж компанийн үндсэн үйл ажиллагаа, зорилт зорилгыг биелүүлэхэд туслалцаа үзүүлэн ажиллаж байгаа төмөр замчин, гаалийн байцаагч, бүртгэгдсэн мэргэжилтнүүдийг компанийн шагналаар шагнаж урамшууллаа. Компаниас өндөр насны тэтгэвэрт гарсан 5 ажилчныг ахмадын баяр болон уламжлалт сар шинийн баярын үеэр гарын бэлэг дурсгалын зүйл гардуулж өгч хэвшсэн ба сум орон нутгийн удирдлагатай хамтран үйл ажиллагаа эрхэлдэг багаас санал болгосон өндөр настан, хөгжийн бэрхшээлтэй болон хагас болон бүтэн өнчин хүүхдүүдэд



эрхэлдэг багаас санал болгосон өндөр настан, хөгжийн бэрхшээлтэй болон хагас болон бүтэн өнчин хүүхдүүдэд гарын бэлэг, бэлэг дургалын зүйл, хичээлийн хэрэглэл гардуулан өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Чулуун Амарсанаа

Албан тушаал: "Э-Транс логистикс" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....

(Тамга/тэмдэг)



Овог, нэр: Содном Тунгалаг

Албан тушаал: "Ихмонгол хөлөг Аудит" ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Содномцэрэн Ганбат

Албан тушаал: Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан

Гарын үсэг: .....

## *Хэлэлцэх асуудал 3*

*Компанийн 2022 оны үйл  
ажиллагааны болон  
санхүүгийн тайлангийн  
талаарх Мөлөөлөн удирдах  
зөвлөлийн дүгнэлт*



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2022 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГАРГАСАН ДҮГНЭЛТ

2023.03.13

Улаанбаатар хот

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж дараах дүгнэлтийг өгсөнг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Э-Транс ложистикс хувьцаат компани нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээгээр 25,442,661.21 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байх ба өнөөгийн нөхцөл байдалд ямар ч байсан тодорхой хэмжээгээр алдагдалгүй ажиллаж компанийн үйл ажиллагааг эрсдэлд оруулалгүй авч явсан нь сайшаалтай гэж дүгнэж байна. Компанийн тайлан мэдээгээр хагас жилийн байдлаар 168,363,503.33 төгрөгийн алдагдалтай ажиллаж цаашдын үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд хэцүү байсан боловч энэхүү алдагдалаа нөхөж бага ч гэсэн ашигтай гаргаж чадсан нь үйл ажиллагаагаа зөв удирдан чиглүүлж ажиллажээ гэж үзэж болохоор байгаа юм.

2022 оны хувьд хил гаалийн асуудал ихтэй өөрөөр хэлбэл БНХАУ-ын хил 2021 оны 10 сарын 14-нөөс бүрэн хаалттай 2 сар болсны дараа зөвхөн шинэ тээврийн хэрэгсэлийг 12 сарын 11-нээс хилийн 0 цэгээс зөөвөрлөж эхэлсэн. Эдгээр нь өдөрт хилээр нэвтрэх тээврийн хэрэгсэлийн тоо хэмжээнд хязгаарлалт тогтоож 40-50 машин орж ирж байсан. Үүний дараагаар шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн 12 сарын 29-нөөс Хятадын гаалийн хашаанд байсан ачаатай машинуудыг оруулж ирсэн, 2022 оны 10 сарын 06-наас чингэлэг тээвэр орж ирсэн, 2022 оны 09 сарын 12-ноос дугаартай тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрч эхэлсэн зэрэг нөхцөл байдал тогтмол өөрчлөгдсөн, үйл ажиллагаагаа удирдан чиглүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал амжилттай ажиллажээ.

Хил гаалийн үйл ажиллагаагаа дагаад үндсэн үйл ажиллагааны хувьд ихээхэн доголдолтой байсан нь харагдаж байна. 2021 онд төмөр замаар 344 вагон импортын ачаа, 548 экспортын ачаа шилжүүлэн ачиж 128 сая төгрөгийн орлого олж байсан бол 2022 онд зөвхөн 50 вагон шилжүүлэн ачиж 27 сая орчим төгрөгийн орлого олжээ. Гаалийн хяналтын бүсээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн хувьд ч мөн 2 дахин буурсан үзүүлэлттэй байна. 2021 оны хувьд 14,677 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан бол 2022 онд 6,489 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн, гаалийн баталгаат агуулахад хадгалуулсан ачаа барааны хадгалалт мөн буурсан зэрэг бүхий л мөнгө санхүүгийн гол гол эх сурвалжууд нь буурсан үзүүлэлттэй байгааг гаргасан тайлан мэдээнээс дүгнэж үзэв.

Гүйцэтгэх удирдлагаас үйл ажиллагаагаа доголдуулахгүйн тулд бүхий л арга хэмжээнүүдийг авч ажилласан нь тайлангаас харагдаж байгаа ба тухайлбал гаалийн хяналтын бүсийн талбайгаа ашиглан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах замаар уул уурхайн бүтээгдэхүүнийг буулгаж ачих, хадгалах, салбар төмөр замаараа даац хэтэрсэн, буруу ачсан ачаатай вагонуудыг хүлээн авч шилжүүлэн ачих, засварлах, өөрийн эзэмшлийн пүүг гаалийн байгууллагад ашиглуулан пүүлсний хураамж авах, зарим агуулах өрөө тасалгаагаа түрээслэх, цайны газраас хоол захиалгаар хүргэлтээр хүргэх зэрэг арга хэрэгсэлүүдийг авч хэрэгжүүлсэн нь хагас жилийн алдагдалыг арилгахад чухал нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн алдагдалыг арилгах ажлуудыг хийж гүйцэтгэхээс гадна жилийн төлөвлөгөөнд заагдсан гаалийн хяналтын бүсийн талбайг хатуу хучилттай болгох ажлыг тодорхой хэмжээнд хийж гүйцэтгэсэн мөн телехяналтын тоног төхөөрөмжүүдийн

шинэчлэлт, гаалийн байгууллагын Genetic системийн өргөтгөл, шинэчлэлт, автопүүний программ хангамж, компьютер авах зэрэг ажлуудыг тодорхой хөрөнгө гаргаж (154,513,022 төгрөг) шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдлыг судлаж үзээд санхүүгийн цэвэр ашиг ногдол ашиг тараах хэмжээнд байхгүй байгаа ч компанийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлээс ногдол ашиг тарааж болох юм гэж үзэн төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ хурлаар энэ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж мөнгөн хөрөнгийн үлдэгдэлээс нэгж хувьцаанд 3 төгрөг байхаар 46,200,000 хувьцаанд нийт 138,600,000 төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн.

Цаашид гүйцэтгэх удирдлагад жилийн стратеги төлөвлөгөөнд заагдсан ажил үйлчилгээгээ чанартай сайн хийж гүйцэтгэн өмнөх жилийн амжилтаа бататган ашигтай ажиллах, хилийн боомтын үйл ажиллагаа эхлэхэд үндсэн үйл ажиллагаагаа зөв удирдан чиглүүлж хяналтын бүсээр үйлчлүүлэх иргэн аж ахуйн нэгжийг бууруулахгүй байх ажлыг гаалийн байгууллагатай хамтран зохион байгуулах, үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтын хувийг өсгөхөд анхаарч ажиллах зэрэг үүрэг даалгаврыг өгч ажиллалаа.

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## Хэлэлцэх асуудал 4

Компанийн 2023 оны  
стратегийн төлөвлөгөө



**А. ӨСӨЛТИЙН ЧИГЛЭЛ:**

5 ЖИЛИЙН ЗОРИЛТ	3 ЖИЛИЙН ДАРААХ ДҮР ЗУРАГ	ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ																			
<p><b>Хугацаа:</b> 2027.12.31</p> <p>Жилдээ 2 тэрбумын орлоготой, 30%-ийн цэвэр ашиг олдог болсон байна.</p>	<p><b>Хугацаа:</b> 2025.12.31</p> <p><b>Дүр зураг:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Бүрэн автоматжуулсан шилжүүлэн ачилтын цогцолбортой</li> <li>Орон нутагтаа болон бусад нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаараа танигдсан</li> <li>ША, ГХБ, БА-аар үйлчлүүлэгчдийн 80 % нь тус компаниар үйлчлүүлэх сонирхолтой</li> <li>Нэгдсэн удирдлагаар хангадаг тогтолцоотой</li> <li>Маркетингийн бие даасан багтай</li> <li>Хөргөлтийн болон вакуумжсан 2-3 агуулахтай</li> <li>Цайны газраар үйлчлүүлэгчдийн тоо өссөн, Замын-Үүд суманд хоол үйлдвэрлэлээрээ танигдсан</li> <li>Үйл ажиллагаандаа мөрддөг урамшуулал, хөнгөлөлтийн цогц бодлоготой болсон</li> </ul>	<p><b>Хугацаа:</b> 2023.12.31</p> <p><b>Гарцын үзүүлэлтүүд:</b> Орлого: 1,6 тэрбум Ашиг: 320 сая Өсөлт: 7 %</p> <p><b>Жилийн гол үр дүнгүүд:</b></p> <table border="1" data-bbox="1370 582 2130 851"> <tr> <td>1</td> <td>Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг 80%-д хүргэсэн.</td> </tr> <tr> <td>2</td> <td>Удирдлагын багийхан ур чадварын хөтөлбөрт хамрагдсан.</td> </tr> <tr> <td>3</td> <td>Компанийн маркетингийн ажлыг тогтмолжуулсан.</td> </tr> <tr> <td>4</td> <td>Шилжүүлэн ачилт, ГХБ, БА дахь үйлчилгээ нэмэгдсэн.</td> </tr> <tr> <td>5</td> <td>ГХБ-ийн үйл ажиллагаа цахимжсан.</td> </tr> <tr> <td>6</td> <td></td> </tr> </table>	1	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг 80%-д хүргэсэн.	2	Удирдлагын багийхан ур чадварын хөтөлбөрт хамрагдсан.	3	Компанийн маркетингийн ажлыг тогтмолжуулсан.	4	Шилжүүлэн ачилт, ГХБ, БА дахь үйлчилгээ нэмэгдсэн.	5	ГХБ-ийн үйл ажиллагаа цахимжсан.	6								
1	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг 80%-д хүргэсэн.																				
2	Удирдлагын багийхан ур чадварын хөтөлбөрт хамрагдсан.																				
3	Компанийн маркетингийн ажлыг тогтмолжуулсан.																				
4	Шилжүүлэн ачилт, ГХБ, БА дахь үйлчилгээ нэмэгдсэн.																				
5	ГХБ-ийн үйл ажиллагаа цахимжсан.																				
6																					
АСУУДАЛ БА БОЛОМЖ																					
<table border="1"> <tr> <td>1</td> <td>Өмнөх жилийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан худалдан авах чадвар муудсан байна.</td> </tr> <tr> <td>2</td> <td>Удирлагын багаас шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүний санал санаачилга гаргах чадвар муутай.</td> </tr> <tr> <td>3</td> <td>Маркетингийн төрөл бүрийн идэвхижүүлэлт хангалтгүй, огт хийдэггүй.</td> </tr> <tr> <td>4</td> <td>ГХБ-ийн ачаалал нэмэгдсэн тохиолдолд талбайн хүчин чадал муудаж байгаль орчинд муугаар нөлөөлөх нөлөөлөл ихсэх эрсдэлтэй. / Тоосжилт, элсний нүүдэл /</td> </tr> <tr> <td>5</td> <td>Боомтын өргөтгөлийн ажил дуусаж байгаа тул хяналтын бүсэд орох техник хэрэгсэл багасах, үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.</td> </tr> </table>	1	Өмнөх жилийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан худалдан авах чадвар муудсан байна.	2	Удирлагын багаас шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүний санал санаачилга гаргах чадвар муутай.	3	Маркетингийн төрөл бүрийн идэвхижүүлэлт хангалтгүй, огт хийдэггүй.	4	ГХБ-ийн ачаалал нэмэгдсэн тохиолдолд талбайн хүчин чадал муудаж байгаль орчинд муугаар нөлөөлөх нөлөөлөл ихсэх эрсдэлтэй. / Тоосжилт, элсний нүүдэл /	5	Боомтын өргөтгөлийн ажил дуусаж байгаа тул хяналтын бүсэд орох техник хэрэгсэл багасах, үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.	<table border="1"> <tr> <td>6</td> <td>Маркетинг, менежмент сайжирснаар компанийн нэр хүнд өсөх боломжтой.</td> </tr> <tr> <td>7</td> <td>Тоног төхөөрөмж, агуулахын шинэчлэлт хийснээр шинэ үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой.</td> </tr> <tr> <td>8</td> <td>MNS 5832:2007 стандартын шаардлагыг хангаснаар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал хангагдаж үйлчилгээ авах сонирхол нэмэгдэх боломжтой.</td> </tr> <tr> <td>9</td> <td>Үйл ажиллагаа цахимжсанаар иргэдэд үйлчилгээгээ цаг алдалгүй авах боломжтой болно.</td> </tr> <tr> <td>10</td> <td></td> </tr> </table>	6	Маркетинг, менежмент сайжирснаар компанийн нэр хүнд өсөх боломжтой.	7	Тоног төхөөрөмж, агуулахын шинэчлэлт хийснээр шинэ үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой.	8	MNS 5832:2007 стандартын шаардлагыг хангаснаар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал хангагдаж үйлчилгээ авах сонирхол нэмэгдэх боломжтой.	9	Үйл ажиллагаа цахимжсанаар иргэдэд үйлчилгээгээ цаг алдалгүй авах боломжтой болно.	10	
1	Өмнөх жилийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан худалдан авах чадвар муудсан байна.																				
2	Удирлагын багаас шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүний санал санаачилга гаргах чадвар муутай.																				
3	Маркетингийн төрөл бүрийн идэвхижүүлэлт хангалтгүй, огт хийдэггүй.																				
4	ГХБ-ийн ачаалал нэмэгдсэн тохиолдолд талбайн хүчин чадал муудаж байгаль орчинд муугаар нөлөөлөх нөлөөлөл ихсэх эрсдэлтэй. / Тоосжилт, элсний нүүдэл /																				
5	Боомтын өргөтгөлийн ажил дуусаж байгаа тул хяналтын бүсэд орох техник хэрэгсэл багасах, үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.																				
6	Маркетинг, менежмент сайжирснаар компанийн нэр хүнд өсөх боломжтой.																				
7	Тоног төхөөрөмж, агуулахын шинэчлэлт хийснээр шинэ үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой.																				
8	MNS 5832:2007 стандартын шаардлагыг хангаснаар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал хангагдаж үйлчилгээ авах сонирхол нэмэгдэх боломжтой.																				
9	Үйл ажиллагаа цахимжсанаар иргэдэд үйлчилгээгээ цаг алдалгүй авах боломжтой болно.																				
10																					

**Б. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ:****УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хугацаа: 2023.06.30

**Гарцын үзүүлэлтүүд:**

Орлого: 650 сая

Ашиг: 120 сая

Өсөлт: 84 %

Ч/Д	Компанийн төслүүд	Хариуцагч
1	Шинэ тоног төхөөрөмж авах	Ерөнхий нягтлан бодогч
2	Хоолны нэр төрлийг нэмэгдүүлж гарцыг сайжруулах	Ахлах тогооч
3	ГХБүсийн үйл ажиллагааг цахимжуулах	Гаалийн хяналтын бүсийн эрхлэгч
4	Маркетингийн идэвхжүүлэлтийг нэмэгдүүлэх	Дотоод ажилтан
5	Агуулахын засвар, зориулалтыг өөрчлөх	Гаалийн хяналтын бүсийн эрхлэгч

Ч/Д	Ерөнхий нягтлан бодогч
1	Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо судалгаа гаргасан.
2	80 тонны автокран авах ажлыг эхлүүлсэн.

Ч/Д	Ахлах тогооч
1	3 нэр төрлийн хоол шинээр цэсэнд орсон.
2	Хоол үйлдвэрлэлийн хугацааг багасгаж аль болох бэлэн хоол гаргах аргад шилжүүлсэн.

Ч/Д	Гаалийн хяналтын бүсийн эрхлэгч
1	Баталгаат агуулахын зориулалтыг өөрчлүүлэх бэлтгэл ажлыг хангасан.
2	ГХБ-ийг цахимжуулах ажлыг эхлүүлсэн.

Ч/Д	Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан
1	Вэб хуудастай уялдсан гар утасны апплейшн зохиолгох ажлыг эхлүүлсэн.
2	ГХБ-ийг цахимжуулах ажлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах
3	Цахимжуулах ажлын анхны туршилтыг хийж гүйцэтгэх
4	Вэб хуудасны хөтлөлт, фэйсбүүк дэх цахим хуудасны хөтлөлтийг сайжруулсан

## *Хэлэлцэх асуудал 5*

*Төлөөлөн удирдах  
зөвлөлийн цалин  
уралшиуллын төсөв.*





2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв

	<b>Зардлын нэр</b>	<b>Нэгжийн зардал</b>	<b>Зардлын дүн / төгрөг /</b>
1	ТУЗ-ын гишүүдийн цалин	-	-
2	ТУЗ-ын нарийн бичгийн цалин	550,000*4	2,200,000
3	Зөвлөх үйлчилгээний хөлс	1,500,000	1,500,000
4	ТУЗ-ын хурлын зардал	100,000	100,000
5	Бичиг хэргийн зардал	1,000,000	1,000,000
6	Бусад / ХЭХ-ын зар гаргах /	500,000	500,000
	<b>Дүн</b>		<b>5,300,000</b>

## *Хэлэлцэх асуудал 6*

*Мөлөөлөн удирдах  
зөвлөлийн энгийн болон  
хараат бус гишүүнд нэр  
дэвшигчид*



**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
ердийн гишүүнд нэр дэвшигч  
Чулуун овогтой Амарсанаа**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Чулуун овогтой Амарсанаа  
Төрсөн он: 1961 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: Э-Транс Ложистикс ХК  
гүйцэтгэх захирал



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1969	1979
2	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль	Уулын инженер	1979	1984
3	БНСЧС улсын Коопцинице мэргэжил дээшлүүлсэн		1989	1990


**3. Ажлын туршлага**

1984-1985 онд Бугантын алтны үйлдвэрт засварчин, туслах эксваторчин  
1985-1991 онд Цагаан дэлийн уурхай, ерөнхий механик  
1991-1995 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэр, Ерөнхий инженер дарга  
1995-2002 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэрийн харьяа Хавчуугийн алтны уурхай, ерөнхий инженер, дарга  
2002-2011 онд Э-Транс ХХК, гүйцэтгэх захирал  
2011 оноос Э-Транс Ложистикс ХК, гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
ердийн гишүүнд нэр дэвшигч  
Энхболд овогтой Батболд**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Энхболд овогтой Батболд  
Төрсөн он: 1987 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: Баянцемент ХХК-ны  
гүйцэтгэх захирал



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1995	2004
2	Тайваны их сургууль	Эрх зүйч	2008	2014

**3. Ажлын туршлага**

2014-2015 онд Тайван дахь худалдаа эдийн засгийн төлөөлөгчийн газарт туслах ажилтан  
2016 оноос Баянцемент ХХК-ны ерөнхий менежер  
2018 оноос Э-Транс ХХК-ны дэд захирал  
2020 оноос Баянцемент ХХК-ны гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
ердийн гишүүнд нэр дэвшигч  
Чулуун овогтой Энхболд**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Чулуун овогтой Энхболд  
Төрсөн он: 1967 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК-ийн  
ерөнхий захирал



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Төв аймгийн Зуунмод хотын 10 жилийн сургууль	Бүрэн дунд	1974	1984
2	Ленинградын Төмөр замын дээд сургууль		1984	1989
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

**3. Ажлын туршлага**

1989-1990 онд УБТЗ-ын өртөө ажилчин  
1990-1992 онд УБТЗ-ын Замын –Үүд өртөө орлогч дарга  
1992-1994 онд УБТЗ-ын Багануур өртөө орлогч дарга  
1992-1997 онд ТУУШИН ХХК ОУ-ын тээвэр зууч, экспортын тээвэрлэлтийн мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
ердийн гишүүнд нэр дэвшигч  
Данзан овогтой Даянбилгүүн**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Данзан овогтой Даянбилгүүн  
Төрсөн он: 1976 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК, гүйцэтгэх захирал



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Нийслэлийн 10 жилийн 5-р сургууль	Бүрэн дунд	1984	1994
2	Европ хэлний дээд сургууль	Бизнесийн эдийн засагч	1994	1998
3	СЭЗДСургууль	Бизнесийн удирдлага, магистр	2003	2005

**3. Ажлын туршлага**

1994-1995 онд Эдийн тэнгэр банк – оператор, нягтлан бодогч,  
1995-1997 онд УИХ-ын тамгийн газар – гишүүний орон тооны ажилтан  
1997-1999 онд “БиДиСек ҮЦК” ХХК – салбарын менежер  
1999-2022 онд “БиДиСек ҮЦК” ХК-ны гүйцэтгэх захирал  
2022 оноос “БиДиСек ҮЦК” ХК-ны ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
ердийн гишүүнд нэр дэвшигч  
Шараа овогтой Шинэбаяр**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Шараа овогтой Шинэбаяр  
Төрсөн он: 1979 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК,  
менежер



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1991	2001
2	Сэрүүлэг дээд сургууль	Бизнесийн удирдлага	2001	2005

**3. Ажлын туршлага**

2007 оноос 2022 он хүртэл “БиДиСек ҮЦК” ХК-нд хөрөнгө оруулалтын алба, менежер,

2022 оноос “БиДиСек ҮЦК” ХК-ны Дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
ердийн гишүүнд нэр дэвшигч  
Бүрэнмэнд овогтой Лхагвадорж**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Бүрэнмэнд овогтой Лхагвадорж  
Төрсөн он: 1976 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК, тэргүүн  
дэд захирал



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1983	1993
2	ШУТИС	Нефтийн инженер	1993	1997

**3. Ажлын туршлага**

1997 оноос БиДиСек ҮЦК ХК, тэргүүн дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Халтар овогтой Батхишиг**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Халтар овогтой Батхишиг  
Төрсөн он: 1974 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: “ Нефть Ойл ” ХХК,  
Захирал



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
	Нийслэлийн 10 жилийн 28-р сургууль	Бүрэн дунд	1981	1991
1	ТИС	Дээд, инженер	1991	1997

**3. Ажлын туршлага**

2004 оноос одоог хүртэл “ Нефть Ойл ” ХХК-ны захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Чулуунбаатар овогтой Оргил**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Чулуунбаатар овогтой Оргил  
Төрсөн он: 1987 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: “МГТБУ” ТӨХХК,  
ГХХ-ийн дарга



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	1-р дунд сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Хан-Уул дээд сургууль	Бакалавр	2005	2010
3	Chinese Culture University	Магистр	2012	2014

**3. Ажлын туршлага**

2015-2017 онд ССХ, судлаач  
2019-2019 онд БНЭУ-ын элчин сайдын яам, Маркетингийн АД  
2019 оноос МГТБУ ТӨХХК, ГХХ-ийн дарга

**“Э-Транс Логистикс” ХК-ийн ТУЗ-ийн  
хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Жаргалсайхан овогтой Энхтулга**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Жаргалсайхан овогтой Энхтулга  
Төрсөн он: 1987 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: Лайф ис Гүүд Монголиа ХХК,  
Нягтлан бодогч



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	СЭЗДСургууль	Бизнесийн удирдлага	2005	2010

**3. Ажлын туршлага**

2011-2011 онд МҮХАҮТанхим, Туслах ажилтан  
2014-2015 онд Лайф ис Гүүд Монголиа ХХК, Худалдан авалтын зөвлөх  
2015-2017 онд Лайф ис Гүүд Монголиа ХХК, Гүйцэтгэх захирал  
2017 оноос Лайф ис Гүүд Монголиа ХХК, Нягтлан бодогч

## *Хэлэлцэх асуудал 7*

*Жоргол ашгийн талаар  
гаргасан шийдвэр*







## Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023. 02 17

№ 01

Борхойн тал

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.1, 46.5, 46.14 дэх заалт, Компанийн дүрмийн 4-р зүйлийн 4.4 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эчнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Э-Транс Ложистикс" ХК-ны 2022 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийн 46 хувь буюу нэгж хувьцаанд 3 төгрөгөөр тооцон 46,200,000 хувьцаанд нийт 138,600,000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэх өдрөөр тасалбар болгосугай.

3. Ногдол ашиг хуваарилах ажлыг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-иар дамжуулан зохион байгуулж 2023 оны 12 сарын 31-ний дотор тухайн компанийн дансанд шилжүүлж дуусгах ба ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД